



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/70

Хэрлэн сум

**Байгууллагын үнэлгээний
баг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний багийн дарга:	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ш.Эрдэнэжаргал	Хүний нөөц, дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
	Б.Дарханбаатар	Хууль эрх зүйн хэлтсийн дарга
	Ж.Саруултөгс	Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
	Л.Цэнддорж	Цэргийн штабын Дайчилгааны офицер
	Б.Ундрахжаргал	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн
	Д.Цэцэгсүрэн	Санхүү төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч
	Ж.Цэнджав	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхжаргал Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтэс

2.Жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр “Маш сайн” үнэлгээний ангилалд хамаарах албан хаагчдыг үндсэн цалингийн 40 хүртэл хувиар урамшуулахаар тогтоосугай.

3.Үнэлгээний багийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг батлагдсан аргачлалын дагуу үнэлж, хянан баталгаажуулж, мэдээллэхийг үнэлгээний баг (Ч.Баярцолмон)-т даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА